

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Марал-Алтай” өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/185/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenhandd@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хорослол, Жинст баг,
Есенбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02.21 № 7

танай _____-ны № _____-т

МАРАЛ-АЛТАЙ ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
С.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Марал-Алтай өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодсх бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар цалингийн урьдчилгаа их хэмжээгээр олгож тухайн сардаа суутгадаггүй, баруун бүсийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн сургалт, уулзалтын хоол, байрны зардлыг төсвөөс төлсөн, нөхөргөлийн хурлын шийдвэргүйгээр даргад урамшуулал олгосон, цалин болон эмийн худалдан авалттай холбоотой өр төлбөр үүсгэсэн, эмийн худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 93,213.1 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.2.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэлгээ хуваарилалт, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

8225020022

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 421,199.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан нь өмнөх оноос 7,894.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Говь-Алтай аймагт баруун бүсийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажилтнуудын сургалт, уулзалтыг зохион байгуулсан байна.

Бусад асуудал

Тайлант онд 1 хөтөлбөр, 4 зорилт, 15 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 15 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 96.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Эрүүл мэндийн газраас үнэлээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	67,367,678.9	70,901,780.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,626.3	1,788,987.1
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	12,626.3	1,788,987.1
31210	Төгрөг	12,626.3	1,788,987.1
31213	Арилжааны банк дахь харилцах	12,626.3	1,788,987.1
33	АВЛАГА	27,257,406.0	27,474,362.0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	27,257,406.0	27,474,362.0
34	УРЬДЧИЛГАА	0.0	1,864,189.0
34710	Урьдчилгаа тооцоо	0.0	1,864,189.0
34713	Цалингийн урьдчилгаа	0.0	1,864,189.0
35	БАРАА МАТЕРИАЛ	40,097,646.5	39,774,242.3
35100	Түүхий эд материал	17,639,374.0	13,731,651.4
35110	Тусгай зориулалттай материал	3,981,300.0	3,981,300.0
35130	Эм боох материал	13,658,074.0	9,750,351.4
35400	Хангамжийн материал	22,458,272.5	26,042,590.9
35410	Бичиг хэргийн материал	5,157,350.0	5,325,750.0
35420	Аж ахуйн материал	16,956,922.5	20,372,840.9
35430	Сэлбэг хэрэгсэл	344,000.0	344,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	53,984,515.0	81,982,792.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	53,984,515.0	81,982,792.2
39200	Биет хөрөнгө	53,984,515.0	81,982,792.2
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,800,000.0	46,775,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,799,999.9)	(17,799,999.8)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	74,007,650.8	78,357,998.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,973,049.5)	(32,425,612.5)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,226,747.0	17,862,734.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,276,833.4)	(10,787,327.4)
39301	Программ хангамж	490,750.0	490,750.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(490,750.0)	(490,750.0)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	121,352,193.9	152,884,572.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,660,528.0	32,996,584.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,660,528.0	32,996,584.9
41300	Өглөг	15,660,528.0	32,996,584.9
41360	Бусад өглөг	15,660,528.0	32,996,584.9
41361	Байгууллагад төлөх өглөг	11,825,639.0	18,113,426.7
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	3,834,889.0	14,883,158.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	105,691,666.0	119,887,987.7
51	Засгийн газрын хувь оролцоо	105,691,666.0	119,887,987.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	24,275,413.7	24,275,413.7
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	24,275,413.7	24,275,413.7
51200	Хуримтлагдсан үр дүн	81,416,252.3	95,612,574.0
51210	Өмнөх үеийн үр дүн	69,937,522.4	81,416,252.3
51220	Тайлант үеийн үр дүн	11,478,729.8	14,196,321.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	121,352,193.91	152,884,572.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	492,784,918.5	488,482,397.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,062,232.4	58,865,697.4
120	Нийтлэг татварын бус орлого	71,062,232.4	58,865,697.4
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	71,062,232.4	58,865,697.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	421,722,686.1	429,616,699.8
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	421,722,686.1	429,616,699.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	421,722,686.1	429,616,699.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	481,306,188.7	474,278,653.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	481,306,188.7	474,278,653.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	481,306,188.7	474,278,653.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,115,490.0	305,934,004.0
210101	Үндсэн цалин	271,115,490.0	305,934,004.0
2102	Ажил олгогчсоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,183,946.9	43,021,990.3
210201	Тэтгэврийн даатгал	23,095,453.0	9,831,301.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,554,861.0	33,190,689.3
2104	Хангамж, бараа материалын зардал	31,944,218.3	8,361,350.0
210401	Бичиг хэрэг	6,815,650.0	2,569,500.0
210402	Тээвэр, шатахуун	4,021,075.0	3,152,700.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,918,114.0	2,314,100.0
210408	Бараа материал акталсны зардал	-	325,050.0
2105	Нормативд зардал	123,718,269.2	60,917,850.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	123,718,269.2	60,917,850.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,947,000.0
210604	Урсгал засвар	-	4,947,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,574,373.3	51,096,459.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	39,374,944.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,368,373.3	11,721,515.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	11,478,729.8	14,203,743.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	7,421.7
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	7,421.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	11,478,729.8	14,196,321.8

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 01-р сарын 31-нэрэх үлдэгдэл	24,275,413.7	1,009,318.0	68,928,204.4	94,212,936.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	1,009,318.0	1,009,318.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,275,413.7	1,009,318.0	69,937,522.4	95,222,254.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	(1,009,318.0)	0.0	(1,009,318.0)
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	11,478,729.8	11,478,729.8
10	2023 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	24,275,413.7	0.0	81,416,252.2	105,691,665.9
11	2024 оны 1-р сарын 1-нэрэх үлдэгдэл	24,275,413.7	0.0	81,416,252.2	105,691,665.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,275,413.7	0.0	81,416,252.2	105,691,665.9
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	14,196,321.7	14,196,321.7
20	2024 оны 12-р сарын 31-нарх үлдэгдэл	24,275,413.7	0.0	95,612,574.0	119,887,987.7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	394,465,280.1	429,399,743.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.0	200,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	0.0	200,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.0	200,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	200,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	394,465,280.1	429,199,743.8
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	8,000,000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	8,000,000.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	394,465,280.1	421,199,743.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	394,465,280.1	421,199,743.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	390,158,034.2	425,373,383.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	390,158,034.2	425,373,383.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,158,034.2	425,373,383.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	388,798,034.2	425,373,383.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	388,798,034.2	425,373,383.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,307,245.9	4,026,360.7

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,350,000.0	2,250,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,350,000.0	2,250,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	4,350,000.0	2,250,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,350,000.0	2,250,000.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=-(IV)-(V)	(4,350,000.0)	(2,250,000.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(42,754.1)	1,776,360.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,380.4	12,626.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,626.3	1,788,987.1

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 37,477.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Үнэ төлбөргүй авсан 37,477.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авснаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасныг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 93,213.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 93,213.1 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрснээс, 9,506.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 73,209.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 10,497.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

3.2 Төлбөрийн акт

1. Ажиллагсдаас 4,800.0 мянган төгрөгийн урьдчилгаа суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Вакум цонх худалдан авахаар 2,880.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч хөрөнгийг бодитоор аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3. Төвийн дарга нөхөрлөлийн хурлын шийдвэргүйгээр 1,826.8 мянган төгрөгийн урамшуулал авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", " Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага

1. Тайлант онд цалингаас суутгасан ХХОАТ 6,986.8 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэл 7,896.3 мянган төгрөг, эмийн өр 18,113.9 мянган төгрөгийг төлөөгүй, өр үүсгэж, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"; гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайланд тусгасан өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

2. Эмийн зардлаас 34,079.7 мянган төгрөгийн эм худалдан авсан бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эмийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Баруун бүсийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн сургалтын үйл ажиллагааны зардалд 6,133.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг сургалтын зардалд зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 10,497.0 мянган төгрөг хасагдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг нэхэмжлэхдээ даатгуулагчийн төлбөрийн тооцоо, холбогдох мэдээллийг үнэн, зөв, цаг хугацаанд нь цахим системд бүртгэж, үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлэн, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**"Марал-Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусгагч илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
"Марал-Алтай" өрхийн эрүүл мэндийн төв	Үнэ төлбөргүй авсан 37,477.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авснаар тайлагнасан	1	37,477.2			1	37,477.2	1	37,477.2				
дүн		1	37,477.2			1	37,477.2	1	37,477.2				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
						Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
"Марал-Алтай" өрхийн эрүүл мэндийн төв	Ажиллагсдаас 4,800.0 мянган төгрөгийн урьдчилгаа суутгаагүй.	1	4,800.0	1	4,800.0	-	-	-	-	-	-
	Вакум цонх худалдан авахаар 2,880.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч хөрөнгийг бодитоор аваагүй байна	1	2,880.0	1	2,880.0	-	-	-	-	-	-
	Баруун бүсийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн сургалтын үйл ажиллагааны зардалд 6,133.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	6,133.0	-	-	1	6,133.0	-	-	-	-
	Төвийн дэрга нөхөр төлийн хурлын шийдвэргүйгээс 1,826.8 мянган төгрөгийн урамшуулал авсан.	1	1,826.8	1	1,826.8	-	-	-	-	-	-



**"Марал-Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	Тайлант онд цалингаас суутгасан ХХОАТ 6,986.8 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэл 7,896.3 мянган төгрөг, эмийн өр 18,113.9 мянган төгрөгийг төлөөгүй, өр үүсгэж төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	32,996.6	-	-	1	32,996.6	-	-	-	-
	Эмийн зардлаас 34,079.7 мянган төгрөгийн эм худалдан авсан бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуул аагүй байна.	1	34,079.7	-	-	1	34,079.7	-	-	-	-
	Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 10,497.0 мянган төгрөг хасагдсан байна.	1	10,497.0	-	-	-	-	1	10,497.0	-	-
дүн		7	93,213.1	3	9,506.8	3	73,209.3	1	10,497.0	-	-

Гав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Аудитад хамрагдах	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр			
			Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		